

ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА I УЛИРАЛД


1. Үнэт цаасны арилжаа

2022 оны I улиралд нийт 59 удаагийн үнэт цаасны арилжаа явагдаж, хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 130 ХК-ийн 96.3 сая ширхэг хувьцааг 95.4 тэрбум төгрөгөөр, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 53.2 мянган ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг 5.3 тэрбум төгрөгөөр, Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 2.6 сая ширхэг нэгж эрхийг 1.2 тэрбум төгрөгөөр, Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаагаар 102 мянган ширхэг бондыг 17.9 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж, нийт 119.83 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн байна.

Тайлант хугацаанд өдөрт дунджаар 1.7 сая ширхэг үнэт цаасыг 2 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

Нийт арилжааны үнийн дүнгийн 79.63 хувь буюу 95.4 тэрбум төгрөгийг хувьцааны арилжаа, 4.42 хувь буюу 5.3 тэрбум төгрөгийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа, 1 хувь буюу 1.2 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа, 14.94 хувь буюу 17.9 тэрбум төгрөгийг компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа тус тус эзэлж байна.

Нийт арилжааны үнийн дүнд эзлэх хувь




НИЙТ АРИЛЖААНЫ ХЭМЖЭЭГ ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛАХАД

2021 он I улирал		Тоо ширхэг /мян/	Арилжааны дүн /тэр бум төг/	2022 он I улирал		Тоо ширхэг /мян/	Арилжааны дүн /тэр бум төг/
Хувьцаа	анхдагч	-	-	Хувьцаа	анхдагч	-	-
	хоёрдогч	245,668.15	65.93		хоёрдогч	96,311.00	95.40
ХБҮЦ	анхдагч	10.00	4.00	ХБҮЦ	анхдагч	50.00	5.00
	хоёрдогч	0.35	0.14		хоёрдогч	3.24	0.32
Компанийн бонд	анхдагч	-	-	Компанийн бонд	анхдагч	-	-
	хоёрдогч	4.63	0.47		хоёрдогч	102.07	17.89
ХОС	анхдагч	-	-	ХОС	анхдагч	-	-
	хоёрдогч	7,163.11	1.31		хоёрдогч	2,623.33	1.21
Нийт		252,846.24	71.84	Нийт		99,089.64	119.83
Өөрчлөлт /%/							66.80

1.1 Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа

Тайлант хугацаанд нийт 59 удаагийн арилжаагаар 130 ХК-ийн 96.3 сая ширхэг хувьцааг 95.4 тэрбум төгрөгөөр арилжсан бөгөөд нийт хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны үнийн дүнгийн 48.68 хувийг багцын арилжаа, 36.11 хувийг энгийн арилжаа, 0.26 хувийг бүгдийг нь биелүүлэх эсвэл үл биелүүлэх дуудлага арилжаа /AON/, 14.94 хувийг тендер арилжаа тус тус эзлэж байна. Нийт 130 компанийн үнэт цаас арилжигдсанаас өмнөх оны мөн үетэй харьцуулахад 53 компанийн үнэт цаасны ханш өсч, 69 компанийн үнэт цаасны ханш буурч, 8 компанийн үнэт цаасны ханш тогтмол арилжигдсан байна.



ИДЭВХТЭЙ АРИЛЖИГДСАН 30 ҮНЭТ ЦААС

ҮНЭТ ЦААС	АРИЛЖИГДСАН ШИРХЭГ '000	№	ҮНЭТ ЦААС	ҮНИЙН ДҮН '000 000
АПУ	32,719	1	АПУ	49,189.64
МОНОС ХҮНС	17,098	2	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	15,457.16
МАНДАЛ ДААТГАЛ	12,121	3	ХӨСӨГ ТРЕЙД	14,264.14
СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС	4,569	4	МОНОС ХҮНС	2,166.77
ГОВЬ	3,878	5	ТҮМЭН ШУВУУТ	1,885.84
ЛЭНДМН ББСБ ХК	3,252	6	АРД ДААТГАЛ ХК	1,678.41
АРД КРЕДИТ ББСБ ХК	3,074	7	МАНДАЛ ДААТГАЛ	1,422.00
ТҮМЭН ШУВУУТ	2,946	8	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙ ШН	1,134.89
РЕМИКОН	2,634	9	ГОВЬ	1,114.57
АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	1,921	10	СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС	863.86
ДАВААНБУЛАГ	1,730	11	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	701.00
АРД ДААТГАЛ ХК	1,678	12	ТАЛХ ЧИХЭР	611.86
ДАРХАН НЭХИЙ	1,434	13	АРД КРЕДИТ ББСБ ХК	518.27
ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙ ШН	1,306	14	Инвекор ББСБ	423.85
ГЕРМЕС ЦЕНТР	1,105	15	МАХИМПЕКС	416.01
МОНГОЛ БАЗАЛТ ХК	768	16	ДАВААНБУЛАГ	392.64
ЭРДЭНЭС СОЛЮШИНС	709	17	БОГД БАНК	375.15
СҮҮ	647	18	СҮҮ	374.30
Бодь Даатгал ХК	351	19	МОНГОЛ ШЕВРО	250.09
АЙ ТҮҮЛС	294	20	Тэнгэрлиг медиа групп ХК	199.60
УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	195	21	ТАВАН ТОЛГОЙ	185.22
ХӨСӨГ ТРЕЙД	195	22	МИК ХОЛДИНГ	183.76
УВС ЧАЦАРГАНА	190	23	БУЛГАН УНДРАГА	181.16
НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	169	24	МОНГОЛ БАЗАЛТ ХК	158.20
БОГД БАНК	148	25	ЛЭНДМН ББСБ ХК	136.43
МАХИМПЕКС	114	26	ГЕРМЕС ЦЕНТР	136.16
ЖЕНКО ТУР БЮРО	111	27	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	134.99
ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ	110	28	МАТЕРИАЛИМПЕКС	95.47
Инвекор ББСБ	104	29	УВС ЧАЦАРГАНА	69.91
ХӨХ ГАН	68	30	ДАРХАН ХӨВӨН	62.00
Нийт	95,637			94,783.36
Нийтэд хувьцаанд эзлэх хувь	99.30			99.33

ХАНШИЙН ӨСӨЛТТЭЙ 20 ҮНЭТ ЦААС

Үнэт цаас	АРИЛЖ ИГДСАН ШИРХЭГ '000	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт	
		2022.03.31	2021.03.31	Төг	Хувь
БУЛГАН УНДРАГА	1.24	101,000.00	6,165.00	94,835.00	1,538.28
Тэнгэрлиг медиа групп ХК	9.46	18,000.00	1,954.00	16,046.00	821.19
МАНДАЛ ГОВЬ ИМПЭКС	0.05	813.33	135.00	678.33	502.47
МОННООС	0.89	10,000.00	1,900.00	8,100.00	426.32
ӨНДӨРХААН	0.08	5,750.00	1,200.00	4,550.00	379.17
ХӨВСГӨЛ УСАН ЗАМ	0.00	1,930.00	450.00	1,480.00	328.89
ХҮННУ МЕНЕЖМЕНТ	0.06	1,490.00	427.89	1,062.11	248.22
ХӨВСГӨЛ ХҮНС	0.01	3,275.00	1,000.00	2,275.00	227.50
АЛТАЙН ЗАМ	0.00	170,000.00	55,000.00	115,000.00	209.09
МОН-ИТ БУЛИГААР	0.03	14,900.00	5,100.00	9,800.00	192.16
ЭРЧИМ БАЯН ӨЛГИЙ	0.05	2,700.00	1,000.00	1,700.00	170.00
ТҮМЭН ШУВУУТ	2,945.80	575.06	213.72	361.34	169.07
СҮҮ	646.56	530.95	212.82	318.13	149.48
УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	194.89	4,302.00	1,727.00	2,575.00	149.10
ХЭРЛЭН ХИВС	0.01	102.00	42.00	60.00	142.86
ХОРИН ХОЁРДУГААР БААЗ	0.01	900.00	379.00	521.00	137.47
ТАЛХ ЧИХЭР	20.50	33,400.00	14,200.00	19,200.00	135.21
СТАНДАРТ НООС	3.51	600.00	260.00	340.00	130.77
ГАН ХЭРЛЭН	0.01	12,160.00	5,320.00	6,840.00	128.57
АПУ	32,719.43	1,572.00	746.58	825.42	110.56

ХАНШИЙН БУУРАЛТТАЙ 20 ҮНЭТ ЦААС

Үнэт цаас	АРИЛЖ ИГДСАН ШИРХЭГ '000	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт	
		2022.03.31	2021.03.31	Төг	Хувь
МОНГЕО	2.78	6,100.00	17,000.00	(10,900.00)	(64.12)
ХАСУ-МАНДАЛ	0.10	3,200.00	7,990.00	(4,790.00)	(59.95)
ТАВ	0.44	6,300.00	13,750.00	(7,450.00)	(54.18)
ЖУУЛЧИН ГОВЬ	0.04	5,800.00	11,950.00	(6,150.00)	(51.46)
АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	1,920.85	5,155.00	10,180.00	(5,025.00)	(49.36)
МОНГОЛ АЛТ	0.22	13,200.00	26,000.00	(12,800.00)	(49.23)
БЭРХ УУЛ	3.48	1,250.00	2,428.00	(1,178.00)	(48.52)
АРД КРЕДИТ ББСБ ХК	3,074.20	140.00	250.23	(110.23)	(44.05)
МОНГОЛ ШУУДАН ХК	33.05	998.40	1,694.00	(695.60)	(41.06)
ХАЙ БИ ОЙЛ	32.99	35.00	58.00	(23.00)	(39.66)
СОНСГОЛОН БАРМАТ	0.04	1,225.00	2,000.00	(775.00)	(38.75)
ТҮШИГ УУЛ	0.03	600.00	975.00	(375.00)	(38.46)
ЭРДЭНЭТ АВТО ЗАМ	0.11	345.00	542.00	(197.00)	(36.35)
ХАРХОРИН	0.50	925.00	1,445.00	(520.00)	(35.99)
НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	169.00	110.00	170.00	(60.00)	(35.29)
ОЛЛОО	26.20	19.00	29.30	(10.30)	(35.15)
АРД ДААТГАЛ ХК	1,677.76	965.58	1,455.00	(489.42)	(33.64)
МОНГОЛЫН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	0.14	2,100.00	3,070.00	(970.00)	(31.60)
РЕМИКОН	2,634.16	23.00	33.15	(10.15)	(30.62)
МОНГОЛ ШИЛТГЭЭН	3.66	398.00	560.00	(162.00)	(28.93)

1.2 Хувьцааны багцын арилжаа

Тайлант хугацаанд 46.4 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 32.4 сая ширхэг хувьцааг багцын арилжаагаар арилжсан байна. Энэ нь нийт хувьцааны арилжааны үнийн дүнгийн 48.68 хувийг эзэлж байна.

ХУВЬЦААНЫ БАГЦЫН АРИЛЖАА

д/д	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг '000	Нийт үнийн дүн '000 000
1	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	147.12	971.40
2	AIC	Ард Даатгал ХК	749.00	711.55
3	APU	АПУ	29,333.81	43,316.05
4	DBL	ДАВААНБУЛАГ	1,729.70	392.64
5	ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ	315.28	250.65
6	HVL	Хөвсгөл	48.69	3.54
7	MVO	МОНГОЛ ШЕВРО	25.28	250.01
8	TCK	ТАЛХ ЧИХЭР	18.00	540.00
9	ULZ	ӨЛЗИЙ- ДУНДГОВЬ	6.80	0.68
НИЙТ			32,374	46,437

2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа

Тайлант хугацаанд “Омни актив ТЗК” ХХК-ийн нийтэд санал болгон гаргасан 2 жилийн хугацаатай, жилийн 14.4 хувийн хүүтэй, нэг бүр нь 100,000 төгрөгийн үнэтэй, нийт 50,000 ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг анхдагч зах зээлд 5.0 тэрбум төгрөгөөр амжилттай арилжлаа. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд 5.3 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь нийт арилжааны үнийн дүнгийн 4.42 хувийг эзэлж байна.

3. Хөрөнгө оруулалтын сангийн арилжаа


Тайлан хугацаанд "Үндэсний хувьчлалын сан" болон "Мандал ирээдүйн өсөлт" хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 2.6 сая ширхэг нэгж эрхийг 1.2 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

4. Компанийн бондын арилжаа

Тайлант хугацаанд хоёрдогч зах зээлд “Эрдэнэс таван толгой” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан ам.долларын I, II транчийн 11.8 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 40.9 мянган ширхэг, "Инвескор ББСБ” ХК, “ЛэндМН” болон “Эрдэнэс таван толгой” ХК-ийн нийтэд санал болгосон I, II транчийн төгрөгийн 6 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 61 мянган ширхэг төгрөгийн өрийн хэрэгсэл тус тус арилжигдсан байна.

5. Зах зээлийн үнэлгээ

Нийт зах зээлийн үнэлгээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.7 их наяд төгрөг буюу 45.61 хувиар өсч, 5 их наяд 375.7 тэрбум төгрөг болсон байна.




ХАМГИЙН ӨНДӨР ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭТЭЙ 30 КОМПАНИ


ҮНЭТ ЦААСНЫ НЭР	ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ /'000 000 000/
АПУ	1671.00
ТАВАН ТОЛГОЙ	362.86
МИК ХОЛДИНГ	305.46
ИНВЕСКОР ББСБ	285.48
ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН ХК	259.67
ГОВЬ	226.23
МОНГОЛ ДААТГАЛ	224.78
СҮҮ	182.15
БОГД БАНК	152.50
УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	151.11
АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	147.51
СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС	145.45
ТҮМЭН ШУВУУТ	115.01
Тэнгэрлиг медиа групп ХК	108.00
МОНГОЛ ШУУДАН ХК	99.43
УБ-БҮК	85.37
МАНДАЛ ДААТГАЛ	63.10
ГУТАЛ	54.50
Мандал Ирээдүйн Өсөлт	47.60
МОНОС ХҮНС	47.24
АРД КРЕДИТ ББСБ ХК	39.17
ТАЛХ ЧИХЭР	34.19
БОДЬ ДААТГАЛ	31.50
ЛЭНДМН ББСБ ХК	28.81
ДАРХАН НЭХИЙ	25.28
АРД ДААТГАЛ ХК	24.14
БЭРХ УУЛ	23.83
ТАНДЭМ ИНВЕСТ ББСБ	23.64
ШИВЭЭ ОВОО	20.13
БАГАНУУР	19.93
Нийт	5,005.04
Нийтэд эзлэх хувь	93.04

6. ИНДЕКС


Тайлант хугацаанд TOP-20 индексийн дээд үзүүлэлт 44 119.22 нэгж, доод үзүүлэлт 36 365.30 нэгж, дундаж үзүүлэлт 40 270.89 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 461.23 нэгжээр буюу 9.99 хувиар өсч, 38 096.88 нэгж болсон байна.



Тайлант хугацаанд MSE-A индексийн дээд үзүүлэлт 15 779.73 нэгж, доод үзүүлэлт 13 680.92 нэгж, дундаж үзүүлэлт 14 657.57 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 753.39 нэгжээр буюу 36.98 хувиар өсч, 13 902.71 нэгж болсон байна.



Тайлант хугацаанд MSE-B индексийн дээд үзүүлэлт 12 488.82 нэгж, доод үзүүлэлт 11 863.47 нэгж, дундаж үзүүлэлт 12 161.91 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 619.41 нэгжээр буюу 5.33 хувиар өсч, 12 229.99 нэгж болсон байна.



АРИЛЖААНЫ АЛБА